

Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	-	-	-	-		Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан сургуулийн өмнөх боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	100%
1.1.1	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, тохирц, нийцлийг турших ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.	-	Боловсролын сайдын тушаал	-	Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал батлагдсан байна.	СӨБ, бага боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийн эх зохиож, түшиц сургуулиудад туршилт зохион байгуулсан	МУЗГ-ын 2024.4.24ний өдрийн 176 дугаар тогтоолоор "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал" батлагдаж,	100%	100%

						байна.	тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Боловсролын сайдын 2024.7.25-ны өдрийн А76 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй 3 удаагийн уулзалт зохион байгуулж, хөтөлбөрийг боловсруулж буй ажлын яцын талаар хэлэлцэн, анхаарах асуудал,хөтөлбөрийн нэршил, нэр томъёо зэргийг жигдлэх талаар зөвлөмж, чиглэл өгч ажиллалаа. Мөн СӨБ-ын шинэчилсэн сургалтын хөтөлбөр болон багшийн гарын авлагын төсөлтэй СӨБХ нэгбүрчлэн танилцаж, анхаарах асуудлын талаар зөвлөгөө өгсөн. Улсын хэмжээнд хөтөлбөрийн туршилт зохион байгуулах арга зүйн талаар мөн		
--	--	--	--	--	--	--------	---	--	--

						хамтарсан уулзалт зохион байгуулж, нийт 18 хүүхдийн цэцэрлэгт (нийслэлээс 6, аймгийн төвөөс 7, сумын 5 цэцэрлэг) турших ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд " Туршилтын цэцэрлэгийн арга зүйч, багш нар, аймаг, нийслэлийн мэргэжилтэнгүүдийг нэгдсэн нэг ойлголттой болгох" сургалтыг зохион байгуулж, нийт 130 гаруй оролцогчид хамрагдсан. СӨБХ-ийн болон Боловсролын ерөнхий газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийг хөтөлбөрийн туршилтын цэцэрлэгүүд дээр ажиллах хуваарь гарган, БСҮХ-ээс боловсруулсан Удирдамж, ажиглалтын хуудасны аргачлалыг		
--	--	--	--	--	--	---	--	--

							ашиглан цэцэрлэгийн өдөр тутмын сургалт, үйл ажиллагаатай танилцан, ажиглалт хийсний зэрэгцээ хөтөлбөрийн туршилтын явцад тулгамдаж буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, багшийн арга зүй, сайн туршлага солилцох зорилгоор туршилтын цэцэрлэгийн "Мэргэжлийн багш нарын бүлэг"-ийн үйл ажиллагаанд тогтмол цахимаар оролцож, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. СӨБ-ын шинэ хөтөлбөрийг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга зүйн сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 15-		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							ны өдрүүдэд Улсын хэмжээний бүх цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 2500 гаруй ажилтныг оролцуулан амжилттай зохион байгууллаа. Хавсралт: 3 файл		
1.2.	Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулах	-	-	-	-		Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн баримт бичгүүдийг шинээр болон шинэчлэн боловсруулан ажиллаж байна.	100%	100%
1.2.1	"Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журам"-ын төслийг боловсруулж батлуулна.	-	Баримт бичиг	-	Журмын төсөл батлуулсан байна.	Журмын төсөл батлуулсан байна.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 21.3-т Энэ хуулийн 21.1.1, 21.1.2-т заасан сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын	100%	90%

						гишүүн батална. гэж ззасны дагуу БШУ-ы сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар баталсан " Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаанд баримтлах чиглэл" -ийг "Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журам" болгон шинэчлэн боловсруулж дуусган, аймаг, нийслэлийн Боловсролын газрын СӨБ хариуцсан мэргэжилтнүүдийг. оролцуулан хэлэлцүүлж, санал авч тусгалаа. Журмын төсөлд үндсэн болон хувилбарт сургалт, үйл ажиллагааг нэг журмаар зохицуулах, цахим сургалтын агуулга, нэмэлт үйл ажиллагааг зохион		
--	--	--	--	--	--	--	--	--

						байгуулах, хэл соёлын ялгаатай мөн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үзүүлэх үйлчилгээ, цэцэрлэгийн номын сангийн үйл ажиллагаа зэрэг агуулгыг нэмж тусган боловсруулсан. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, улсын хэмжээнд хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж байгаатай холбогдуулан "Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журам"- ын төсөлд тусгасан зохицуулалт нь хөтөлбөрийн туршилтын явцад нийцэж буй эсэхийг хамт туршиж, туршилт зохион байгуулж буй 18 цэцэрлэгт сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж		
--	--	--	--	--	--	--	--	--

							буй явцтай газар дээр нь танилцан, багш нартай санал солилцон ажиллаж байна. Энэхүү журам нь СӨБ-ын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг тул хөтөлбөрийн туршилтын үр дүнтэй хамт журмын төслийг эцэслэн Сайдын тушаалаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
1.2.5	Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Баримт бичиг	БСШУС-ын сайдын 2019 оны А/854 дүгээр тушаал	-	Журам шинэчлэн батлуулсан байна.	"Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай А/95 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан.	100%	100%

							Мэргэшлийн зэрэг олгох нь албан тушаалын үндсэн чиг үүргээ гүйцэтгэл, үр дүн сайтай хэрэгжүүлсэн, мэргэшлийн ур чадвар, арга зүй туршлагаараа байгууллага, орон нутаг, улсын хэмжээнд манлайлан, бусдад түгээн дэлгэрүүлж, хамтран суралцах, зөвлөн чиглүүлэх түвшинд хүрсний баталгаа болох бөгөөд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чиглэнэ. Журмаар багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан, ил тод, нээлттэй, мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг эрхэмлэсэн, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нээлттэй, ил тод байх зарчим		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							баримтлахаар журамласан. Хавсралт: 1 файл		
1.2. 6	Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага боловсруулж батлуулна.	-	Баримт бичиг	БСШУС-ын сайдын 2019 оны А/430 дугаар тушаал	Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулсан байна	Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, батлуулсан байна	“Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага” болон “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”-ыг Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Нийтлэг шаардлага батлах тухай” А/107 дугаар тушаалын хавсралтаар тус тус батлуулан Боловсролын ерөнхий газарт 2027.09.27-ны өдрийн 12/1242 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тушаалын	100%	100%

							хавсралтаар баталсан нийтлэг шаардлагад нийцүүлэн цэцэрлэгийн багш, арга зүйчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус даалгасан. Хавсралт: 1 файл		
1.2.7	"Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журам"-ын төслийг боловсруулна.	-	Баримт бичиг	БСШУС-ын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн	Журмын төсөл боловсруулсан байна.	Журмын төсөл боловсруулсан байна.	Шинэчлэн боловсруулсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 27.7-д Боловсролын болон суралцагчийн үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн	100%	90%

				хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"			Засгийн газрын гишүүн батална, мөн тус хуулийн 26.2.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр хүүхдийн сургуульд суралцахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тогтооно гэж заасан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд өмнө нь хүчин төгөлдөр хэрэгжиж буй Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар баталсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-ыг шинэчлэн боловсруулж дуусгалаа. Журмын төсөлд дараах өөрчлөлт		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						оруулсан. Үүнд: i) Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ нь бага боловсролын гарааны үнэлгээ ту Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн үнэлгээний журамд оруулахаар хэлэлцэж тохирсон тул хассан ii) Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ын 4.5- д заасан "Суралцагчийн үнэлгээ" -ны агуулга, зарчимд нийцүүлэн тус тус өөрчлөлт орууллаа. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийг оношлох, явцын, үр дүнгийн гэсэн үнэлгээгээр үнэлэх ба энэхүү журмын төсөлд оношлох үнэлгээ болон холимог сургалтад		
--	--	--	--	--	--	--	--	--

							хамрагдаж хүүхдийг үнэлэх арга зүйг шинээр тусган төслийг боловсруулж дуусгасан болно. Хавсралт: 1 файл		
1.2.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэг, хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлгийн орон тооны хязгаарын жишиг нормативын төсөл боловсруулж, батлуулна.	-	Баримт бичиг	Төсөл боловсруулсан.	-	Жишиг нормативыг батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай" А85, А34 дүгээр хамтарсан тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн болон салбар бүлгийн орон тооны нормативыг бүлгийн тоотой уялдуулан шинээр боловсруулж батлууллаа. Энэхүү жишиг нормативаар цэцэрлэгийн болон салбар бүлэгтэй цэцэрлэгийн орон тоог тусад нь тэдний үйл	100%	100%

							ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулсны зэрэгцээ Боловсролын Ерөнхий хуульд Хүүхдийн цэцэрлэгт шинээр ажиллахаар хуульчлагдсан хүний нөөцийн орон тооны жишиг нормативыг тусган батлуулсан. Хавсралт: 1 файл		
1.2.9	"Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам" шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Баримт бичиг	БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаал	-	Журам шинэчлэн батлуулсан байна.	"Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/115 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулж батлуулсан. "Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ"-ний зорилго нь сургалт, үйл ажиллагааны чанар, хүүхдийн хөгжлийн ахиц үр	100%	100%

						дүнг үнэлж, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулах, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг төлөвшүүлэхэд чиглэгдсэн.		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.	-	-	-	-	Сургуулийн өмнөх боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэх, лавлагаа тодорхойлолтын санг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалттай хувийн цэцэрлэгийн Сургуулийн өмнөх боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг	100%	100%

							шинээр олгох, сунгах, хүчингүй болгох зэргийг цахим хэлбэрээр олгож байна.		
3.1.1	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний санг баяжуулж, боловсролын төрийн цахим үйлчилгээн тоог нэмэгдүүлнэ.	-	Лавлагааны санг баяжуулсан тоо, Цахимаар үйлчилгээ үзүүлсэн тоо, Нэмэгдсэн үйлчилгээний тоо	2023-2024 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 151,917, ЕБС-д суралцаж буй 776,876, СӨБ суралцаж буй 275,25, НТБТ-д суралцаж буй 5,127 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 417,850 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна.	Боловсролын яамнаас олгож буй тусгай болон энгийн зөвшөөрөл цахим хэлбэрт шилжсэн байна.	Лавлагаа тодорхойлолтын сан 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024.02.26-ны өдрийн "Зөвшөөрлийн гэрчилгээ батлах тухай" А89 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд дараах ажлыг зохион байгуулаад байна. i) License.mn цахим сайтад гадаадын хөрөнгө оруулалттай хувийн өмчийн 7	100%	100%

						цэцэрлэгийн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийг байршууллаа. ii) Гадаадын хөрөнгө оруулалттай "Хүүхдийн баясгалан", "Баянхошуу Сэйнт поул" цэцэрлэгийн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, "Глобал" цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг үйл явцыг License.mn цахим сайт дээр зохион байгуулж, Боловсролын яамнаас олгож буй тусгай зөвшөөрлийг цахимаар олгож байна. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн		
--	--	--	--	--	--	---	--	--

							Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийг License.mn байршуулах, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Системийн хөгжүүлэлт хийхэд шаардлагатай ажлын даалгаврын төсөл, энгийн зөвшөөрлийг сунгах, шинэчлэх, дахин олгох, нэмэлт өөрчлөлт оруулахад бүрдүүлэх материалын жагсаалтын төслийгЦахим боловсролын газартай хамтран боловсруулж дуусгасан. Хавсралт: 4 файл		
3.1.2	Боловсролын салбарын энгийн болон тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт	-	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	2023 оны гүйцэтгэл	Тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн системийг	Боловсролын яамнаас олгодог энгийн болон тусгай	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024.02.26-ны өдрийн "Зөвшөөрлийн	100%	70%

	шилжүүлнэ.				хөгжүүлсэн байна.	зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	гэрчилгээ шинэчлэн батлах тухай" А89 дүгээр тушаалын хэрэгжилтийн хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд дараах ажлыг зохион байгуулаад байна. i) License.mn цахим сайтад гадаадын хөрөнгө оруулалттай хувийн өмчийн 7 цэцэрлэгийн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тусгай зөвшөөрлийн мэдээллийг байршууллаа. ii)		
--	------------	--	--	--	----------------------	--	---	--	--

						Гадаадын хөрөнгө оруулалттай "Хүүхдийн баясгалан", "Баянхошуу Сэйнт поул" цэцэрлэгийн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, "Глобал" цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг үйл явцыг License.mn цахим сайт дээр зохион байгуулж, тусгай зөвшөөрлийг цахимаар олголоо. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийг License.mn байршуулах, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна.		
--	--	--	--	--	--	--	--	--

							Шаардлагатай ажлын даалгаврын төсөл, энгийн зөвшөөрлийг сунгах, шинэчлэх, дахин олгох, нэмэлт өөрчлөлт оруулахад бүрдүүлэх материалын жагсаалтын төслийг боловсруулан, системийн хөгжүүлэлт хийж буй мэргэжлийн байгууллага, Цахим боловсролын газартай хамтран ажиллаж байна. Хавсралт: 4 файл		
3.2.	Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах	-	-	-	-		Сургуулийн өмнөх боловсролын салбарын Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж байна.	100%	100%
3.2.1	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн ажлыг	Үйл ажиллагааны зардлаар	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын	Цэцэрлэг /байгууллага/ - 90.2 Цэцэрлэг	-	Цэцэрлэг /байгууллага/ - 92 Цэцэрлэг	Сургуулийн өмнөх боловсролын багшийн гүйцэтгэлийн	100%	100%

	үнэлэх, дүгнэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангана.		байгууллага болон багшийн үнэлгээний үр дүн	/багш/ - 90.11		/багш/ - 92	үнэлгээг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд БҮТ-тэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж, даалгавар боловсруулах болон үнэлгээ зохион байгуулах аргачлал дээр зөвлөмж чиглэл өгч ажилласан. Мөн багшийн үнэлгээний үр дүнд дүн шинжилгээ хийсэн бөгөөд анхаарах асуудал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал боловсрууллаа. Сургалт, үйл ажиллагааны үр дүн-90,7 Хүүхдийн хөгжлийн ахиц үр дүн-92,1 Орчинд эрүүл аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт ханган ажилласан ажлын үр дүн-95,0 /БӨ аймаг- 84,9, Багахангай-88,9, Говьсүмбэр аймаг- 89,8/ Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах		
--	---	--	--	-----------------------	--	--------------------	--	--	--

						болзошгүй эрсдлэлд өртөхөөс сэргийлж, осол гэмтэлгүй ажилласан ажлын үр дүн-76,7 байна. Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц үр дүн-13,5 (цэцэрлэгээр) Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төлөвлөлт, биелэлт, үр дүн-90,3, Ажлын байранд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, хамтран ажиллах, туршлагаа хуваалцах ажлын гүйцэтгэлийн үр дүн-80,9 Сургалт, үйл ажиллагаанд тоглоом наадгай, хэрэглэдэхүнийг бэлтгэж ашигласан ажлын үр дүн-83,0 Багшийн ёс зүй хэмжээг мөрдөж ажилласан үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн-95,0 хувьтай		
--	--	--	--	--	--	---	--	--

							байгаа бөгөөд аймаг, дүүрэг бүрээр өмнөх хичээлийн жилтэй харьцуулан анхаарах асуудлын талаар аймаг, дүүргийн Боловсролын газрын дарга нарт чиглэл өгч, багш нарт зориулсан зөвлөмж боловсруулан, сургалт зохион байгуулж 8900 орчим багшийг хамрууллаа.		
3.2. 2	Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж, зөвлөмж боловсруулна.	-	Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээ	70.22	-	Цэцэрлэг /байгууллага/ - 92 Цэцэрлэг /багш/ - 92 Сургууль /байгууллага/ - 76,5 Сургууль /багш/ - 77,5	Энэ хичээлийн жилийн Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 2024 оны 9 дүгээр сарын 2 дугаар долоо хоногт улсын хэмжээнд зохион байгуулагдаж, 21 аймаг, 9 дүүргийн 788 сургуулийн нэгдүгээр ангийн 73.723 сурагч хамрагдсан. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах цахим зөвлөлдөх	100%	100 %

						уулзалтыг хамтран зохион байгуулж, . Хүүхдийн хөгжлийн чиглэлээр авч үзвэл Танин мэдэхүйн хөгжлийн үр дүн бусад хөгжлийн чиглэлийн үр дүнгээс бага байгаа бөгөөд хөгжим, хэл ярианы сургалтын чиглэлийн даалгаврын гүйцэтгэл бусад сургалтын чиглэлээс бага үр дүнтэй гарч байна. Боловсролын үнэлгээний төв СБҮ-ийн тайлан, үр дүнг нэгтгэн гаргаж байгаа бөгөөд эцэслэн гараагүй байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний өнгөрсөн жилийн тайланд үндэслэн БЕГ тай хамтран Бэлтгэл бүлгийн багш нарт зориулсан зөвлөмж боловсруулан цахимаар хүргэсний зэрэгцээ		
--	--	--	--	--	--	---	--	--

							Улсын хэмжээнд Бэлтгэл бүлэг хариуцан ажиллаж буй багш нарт 2 өдрийн сургалт амжилттай зохион байгууллаа. Хавсралт: 1 файл		
3.3.	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, тэгш хамруулан сургах бодлогын удирдлага зохицуулалтыг хангах	-	-	-	-		Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах, алслагдсан бүс нуагт амьдарч буй малчдын болон хилийн заставт амьдарч буй бага насны хүүхдийг хувилбарт сургалтын үйлчилгээнд хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах тойрог харгалзахгүй боловсролын үйлчилгээнд хамруулах зэрэг арга хэмжээг	100%	100%

							удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж байна.		
3.3.1	Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Ажлын гүйцэтгэл	-	Зөвлөмж боловсруулан , хэрэгжилтийг хангасан байна.	Зөвлөмж боловсруулан, хэрэгжилтийг хангасан байна.	Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын баталсан "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах талаар 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: i) улсын хэмжээнд малчин өрхийн 0-6 хүртэлх насны хүүхдийн судалгааг засаг захиргааны нэгжээр нарийвчлан гаргасан. ii) Өнгөрсөн хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт ялангуяа	100%	100%

							хувилбарт сургалтын хамран сургалт улсын дунджаас доогуур үзүүлэлттэй аймгийн Боловсролын газарт 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлээ. iii) Өнгөрсөн хичээлийн жилд Хувилбарт сургалт зохион байгуулсан цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны чанар, хүртээмж, санхүүжилтийн талаарх тайланг авч, аймаг бүрээр нэгтгэн, ирүүлсэн тайлангийн дүгнэлтэд үндэслэн Зөвлөмж боловсруулан, хариу арга хэмжээ авч ажиллах талаар Боловсролын ерөнхий газарт албан бичиг хүргүүлэн,		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллалаа. 2024 онд малчин өрхийн 2-5 насны 51,369 хүүхэд байгаа ба 2024-2025 оны хичээлийн жилд 32.282 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 62.8 хувь хүрч, өнгөрсөн хичээлийн жилээс 10.8 хувиар өссөн байна. Хавсралт: 5 файл		
3.4.	Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах	-	-	-	-		Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг ханган ажиллаж байна.	100%	100%
3.4.1	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгад нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн	-	Ажлын гүйцэтгэл	Туршилтын төлөвлөгөө боловсруулсан.	Нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвар эзэмшүүлэх хөтөлбөрийн туршилт	Туршилтын ажлыг эхлүүлсэн байна.	ЗГ-ын 2024.4.24ний өдрийн 176 дугаар тогтоолоор "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын	100%	100%

чадварыг тусган, хөтөлбөрийн туршилт зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.				зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.		сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал" батлагдаж, Боловсролын сайдын 2024.7.25-ны өдрийн А76 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй 3 удаагийн уулзалт зохион байгуулж, СӨБ-ын шинэчилсэн сургалтын хөтөлбөрт "Нийгэмшихүй - сэтгэл хөдлөл" сургалтын чиглэл болгон авч, агуулгыг бүлэг бүрээр хүүхдэд эзэмшүүлэх чадамжаар тодорхойлж, тоглоом болон зохиолд суурилсан арга зүйгээр эзэмшүүлэхээр тусгаж, 18 хүүхдийн цэцэрлэгт хөтөлбөрийн туршилтыг зохион байгуулж байна. (нийслэлээс 6, аймгийн төвөөс 7, сумын 5 цэцэрлэг).		
--	--	--	--	--	--	---	--	--

							Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад тулгамдаж буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, багшийн арга зүй, сайн туршлага солилцох зорилгоор туршилтын цэцэрлэгийн багш нарын "Нийгэмшихүй - сэтгэл хөдлөл" сургалтын чиглэлийн цахим анги үүсгэн, үйл ажиллагаанд тогтмол цахимаар оролцож, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
3.4.3	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт үндэсний өв соёл, уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээг эзэмшүүлэх агуулгыг тусгах,	-	Ажлын гүйцэтгэл	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлээ боловсруулах ажлын хэсэг Боловсролын сайдын А/06	-	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг туршсан байна.	МУЗГ-ын 2024.4.24ний өдрийн 176 дугаар тогтоолоор "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"	100%	100%

хүүхдийн хэл ярианы хөгжил, эх хэлээрээ ярих чадварыг дэмжих, сургалтын хөтөлбөрийн туршилтыг удирдлага, зохион байгуулалтаар хангах.			дугаар тушаалаар байгуулагдсан.			батлагдаж, тогтоолын хэрэгжилтийн хүрээнд БЯ-ны сайдын 2024.7.25-ны өдрийн "Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах багийн бүрэлдэхүүн батлах тухай" А06 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг СӨБ-ын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. СӨБ-ын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн "Хэл яриа" сургалтын чиглэлийн агуулгыг бүлэг бүрээр хүүхдэд эзэмшүүлэх чадамжаар тодорхойлж, тоглоом болон зохиолд суурилсан арга зүйгээр эзэмшүүлэхээр тусгаж, 18 хүүхдийн		
---	--	--	---------------------------------	--	--	---	--	--

							цэцэрлэгт хөтөлбөрийн туршилтыг зохион байгуулж байна. (нийслэлээс 6, аймгийн төвөөс 7, сумын 5 цэцэрлэг). Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад тулгамдаж буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, багшийн арга зүй, сайн туршлага солилцох зорилгоор туршилтын цэцэрлэгийн багш нарын "Хэл яриа сургалтын чиглэл" ийн бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн цахим ангиын ажиллагаанд тогтмол цахимаар оролцож, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.		
3.4.4	Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд сэтгэл	-	Сургалтад хамрагдсан арга зүйчийн тоо	Сургалтын модуль боловсруулсан, 25 сургагч багш	-	Төрийн өмчийн цэцэрлэгийн 934 арга зүйч хамрагдсан	"Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд сэтгэл	100%	100%

	зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалтыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.			бэлтгэгдсэн.		байна.	зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалт" -ыг 2023 онд НҮБ -ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр МУИС-ийн Сэтгэл судлалын танхимын багш, сэтгэл зүйч нартай хамтран сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, 2024 онд Нийслэлийн Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн арга зүйч нарыг хамруулсан 3 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулж, үндэсний хэмжээнд 25 "Сургагч багш" бэлтгэсэн. Боловсруулсан модулийг дахин сайжруулах, цахим гарын авлага болгох, Сургагч багш нараараа дамжуулан улсын хэмжээнд 930 цэцэрлэгийн арга зүйч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулахаар		
--	--	--	--	---------------------	--	---------------	--	--	--

							НҮБ-ын Хүүхдийн Сантай тохирч Сургагч багш бэлтгэсэн боловч санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа талаар хариу ирүүлсэн. Төлөвлөсөн ажил Нийслэлийн БЗД-ийн 25 цэцэрлэгт амжилттай хэрэгжсэн. Үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажил санхүүжилтээс шалтгаалан хойшлогдсон. Хавсралт: 1 файл		
3.4.5	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөмж боловсруулан цахим сургалт зохион байгуулна.	-	Боловсруулсан зөвлөмж, сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо	-	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж ажилласан байна.	Зөвлөмж боловсруулж, цахим сургалтад 1410 удирдах ажилтан хамрагдсан байна.	1.Цэцэрлэгийн менежментэд дэмжлэг үзүүлэх, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө хийхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2024 оны 01 сарын 15-с - 02 сарын 09-ний хооронд 21 аймаг, 9 дүүрэгт зөвлөн туслах ажлыг зохион байгуулж төрийн болон орон	100%	100%

							нутгийн өмчийн 987 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, 21 аймаг 9 дүүргийн 32 мэргэжилтэн нийт 1480 удирдах ажилтан хамрагдаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. Хүүхдийн цэцэрлэгийн менежментийг сайжруулах ажлын төлөвлөгөөний хүрээнд 2024 оны 12 сард Өөрийн үнэлгээнд суурилсан цэцэрлэгийн менежментийг сайжруулах ажлын үр дүнг үнэлэх, сонгогдсон цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаанд зөвлөн туслах эцэг эх, асран хамгаалагч, хамт олны саналыг сонсох, сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулахад нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						зорилгын хүрээнд ямны СӨБХ, БЕГ, НБГ-ын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжлнүүдээс бүрдсэн баг 2024.11.18-наас Зөвлөн туслах ажлыг аймаг, нийслэлд зохион байгуулж байна. Энэхүү цэцэрлэгийн менежментийн зөвлөн туслах ажилд 118 цэцэрлэг хамрагдаж байгаа ба үүнээс 9 дүүргээс 34 цэцэрлэг, аймаг, сумаас 84 цэцэрлэг байна. Дээрх зөвлөн туслах ажлын үр дүнд цэцэрлэгүүдийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гарч, олон нийтийн оролцоо сайжирч, сайн туршлагууд нэмэгдсэн, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээнд ахиц гарсан үр дүнтэй байна. Цаашид		
--	--	--	--	--	--	--	--	--

						цэцэрлэгийн менежментийг сайжруулах чиглэлээр туршилтын 30 цэцэрлэгийн туршилтад үндэслэн “Цэцэрлэгийн менежмент II” зөвлөмж, гарын авлага, "Цэцэрлэгийн менежментийг сайжруулах сайн туршлагын эмхтгэл"-ийг 2024 оны 12 дугаар сард бэлэн болгож нийт сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2025 оны I улиралд хүргэхээр ажиллаж байна. Хавсралт: 17 файл		
3.5.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах	-	-	-	-	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж байна.	100%	100%

3.5. 1	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах.	-	Арга хэмжээний хэрэгжилт	2023 онд 11 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	2024 онд төлөвлөгдсөн 12 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	2024 онд төлөвлөгдсөн 12 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус орон нутгийн зөвлөлийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 16 аймаг, нийслэл /нийслэлийн 4 дүүрэг/ байгуулан ажиллаж байна. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн орон тооны бус зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг ХНХЯ, ЭМЯ, НҮБ-ын ХСтай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулж, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, боловсрол, гэр бүл хүүхэд залуучуудын асуудал хариуцсан 86 мэргэжилтэн /зөвлөл тус бүрээс	100%	100%
-----------	--	---	--------------------------	--	---	---	--	------	------

							3 гишүүн/ хамрагдсан. Эцэг эх,асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх сургагч багш бэлтгэх ажлыг үндэсний сүлжээ байгууллага “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв” ТББ-тай хамтран эцэг эхийн төлөөллөөс 20 сургагч багшийг 22 дэд сэдвээр сурган бэлтгэж, 7 цуврал 17500 ширхэг гарын авлага, боршур боловсруулж, Баянзүрх дүүрэг, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өмнөговь 4 аймагт туршин нийт 50,000 эцэг эх, асран хамгаалагч хамруулах зорилт тавин сургалтуудыг зохион байгуулж байна. Боловсролын яам, Эрүүл мэндийн яамны харъяа Эрүүл Мэндийн хөгжлийн төв, НҮБ-ын Хүүхдийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						Сангийн мэргэжилтнүүдийн хамт “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ”-ний хэрэгжилт, суралцагчийн эрүүл мэнд, хүүхэд хамгааллын чиглэлээр 2024 оны 10 сарын 14-17-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон, Булган аймагт ажиллан, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллсан. Мөн Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлыг судлан 2025 оны ажлын зураглалыг гаргаж байна. Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хамтран хэрэгжүүлж буй “Бага насны хүүхдийн цогц		
--	--	--	--	--	--	--	--	--

							хөгжлийг дэмжих арга хэмжээ"-ний хэрэгжилтийн чиглэл тус бүрээр тайланг бичиж word хэлбэрээр хавсралтад байршуулсан. Хавсралт: 24 файл		
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
4.1.	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах	-	-	-	-		Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнаж ажиллаж байна.	100%	100%
4.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	-	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг заасан хугацаанд гүйцэтгэж ажиллалаа.	100%	100%
4.1.2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн	-	Хууль, тогтоомж, тогтоол	2023 оны биелэлтийн	Холбогдох заалтын хэрэгжилт	Холбогдох заалтын хэрэгжилт	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн	100%	100%

	биелэлтийг тайлагнах		шийдвэрийн тоо	хувь	хангагдсан байна.	хангагдсан байна.	биелэлтийн тайланг заасан хугацаанд гүйцэтгэж ажиллалаа.		
4.1.3	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2022 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гүйцэтгэж ажиллалаа.	100%	100%
4.1.4	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг заасан хугацаанд тайлагнасан.	100%	100%
4.1.5	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	-	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд	Тухай бүр Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.	100%	100%

					дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.			
4.2.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	-	-	-	-	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	100%
4.2.1	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	-	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	Эхний хагас жилд: : 1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Эхний хагас жилд: : 1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Тухай бүр Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.	100%	100%

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)